

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 25/07

Улаанбаатар хот

Хэлцэл хийх эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 83 дугаар зүйлийн 83.8 болон Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.18-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Богд банкны хувьцааг худалдах буюу арилжихаар дараах байдлаар шийдвэрлэв. Үүнд:
 - 1.1 “Бодь даатгал” ХК-ийн эзэмшлийн хөрөнгө оруулалтын багц дахь Богд банкны 10,259,200 ширхэг хувьцааг нэгж бүрийн үнийг 89.75 төгрөгөөр тооцон, 920,763,200/есөн зуун хорин сая долоон зуун жаран гурван мянга хоёр зуу/ төгрөгөөр бусдад худалдан борлуулах, арилжихыг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт даалгасугай.
 - 1.2 Төлбөр тооцоог нэг метр квадрат талбайн үнийг 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгөөс дээшгүй үнээр тооцон бүрэн ашиглалтад орсон зах зээлд түргэн борлогдох боломжтой үл хөдлөх хөрөнгө (орон сууц)-өөр арилжих, зөрүүт төгрөгөөр хүлээн авахыг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт зөвшөөрсүгэй.
 - 1.3 Хувьцааг үл хөдлөх хөрөнгөөр арилжсан тохиолдолд хүлээн авсан хөрөнгийн эрхийг тогтоол батлагдсанаас хойш 30 хоногийн дотор худалдан борлуулахыг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт үүрэг болгосугай.
2. “Бодь даатгал” ХК-ийн нэг бүрийн үнийг 124 төгрөгөөр тооцсон нийт 4,033,583 ширхэг халаасны хувьцааг “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн нэг бүрийн үнийг 3,330 төгрөгөөр тооцсон нийт 150,151 ширхэг хувьцаагаар эд хөрөнгө буцаан шилжүүлэх/нэг жилийн хугацаатай/ болзолтой арилжааны гэрээ хийж, бусдад шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт зөвшөөрсүгэй.
3. “Бодь даатгал” ХК-ийн 2021 – 2022 онуудын хөрөнгө оруулалтын өгөөж болох 102,300,000 /нэг зуун хоёр сая гурван зуун мянга/ төгрөгөөр “Мөнхийн үсэг” ХХК-ийн нэг жилийн хугацаатай 21-н хувийн хүүтэй өрийн бичиг худалдан авах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт олгосугай.
4. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, “Бодь Даатгал” ХК-ийг төлөөлж холбогдох гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт олгосугай.
5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дотоод аудит Ш.Бэжид-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ